



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2021

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

Уг судалгаанд тусгасан дүгнэлт, зөвлөмж нь уг судалгааг бичиж боловсруулсан судлаачдын дүгнэлт, санал болно.

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу
Засгийн газрын III байр
Утас: (976-11)-321433, (976-11)-263966
Лавлах утас: 1900-1212
Цахим хуудас: www.nso.mn
Цахим хаяг: information@nso.mn

АГУУЛГА

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	4
НЭГ ДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ	5
Судалгааны зорилго, ач холбогдол	
Хууль, эрх зүйн орчин	
Судалгааны хамрах хүрээ	
Ойлголт, тодорхойлолт, ангилал	
Асуулгын хуудас	
Мэдээлэл цуглуулалт	
ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ҮНДСЭН ҮР ДҮН	10
Төрийн албан хаагчдын ерөнхий мэдээлэл	
Үндэсний бичигт шилжихэд бэлэн эсэх, сургалтын хэрэгцээ	
Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг	
ДҮГНЭЛТ	22
АСУУЛГЫН ХУУДАС	24

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төрийн албан хаагчид, боловсролын түвшнээр, хувиар	10
Зураг 2. Төрийн албан хаагчид, албан тушаалын төрлөөр, аймаг, нийслэлээр, хувиар.....	11
Зураг 3. Албан хэргээ кирилл болон Үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн байдал, аймаг, нийслэлээр, хувиар	13
Зураг 4. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх, аймаг, нийслэлээр, хувиар	15
Зураг 5. Сургалт зохион байгуулах хэлбэр, аймаг, нийслэлээр, хувиар	16
Зураг 6. Сургалт зохион байгуулах хэлбэр, насны бүлгээр, хувиар	17
Зураг 7. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, аймаг, нийслэлээр, хувиар	18
Зураг 8. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, насны бүлгээр, хувиар	19
Зураг 9. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, үндэсний бичиг заалгасан жилээр, хувиар. ...	20
Зураг 10. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, төрийн албан хаагчийн албан тушаалын төрлөөр, хувиар	20
Зураг 11. Өгөгдсөн эхийг унших чадвар, хувиар	21
Зураг 12. Өгөгдсөн эхийг унших чадвар, үндэсний бичиг үзсэн жилээр, хувиар	21

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Судалгааны зорилго нь:

- Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлж Монгол Улсын Монгол хэлний тухай хуулийг дагаж мөрдөхөд бэлэн эсэхийг үнэлэх

Судалгааны ач холбогдол:

- Монгол Улсын Монгол хэлний тухай хууль болон “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III (2020-2024)”-ын хэрэгжилтийг үнэлж, дүгнэнэ.
- Үндэсний бичгийн талаар төрөөс авч, хэрэгжүүлэх бодлого, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулахад шаардлагатай тоо, мэдээллийг бий болно.
- Үндэсний бичгийг төрийн албан ёсны үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хэрэгцээтэй сургалтыг үе шаттайгаар төлөвлөх, төлөвлөгөө боловсруулна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Их хурлаас 2015 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Монгол хэлний тухай хуулийг баталж, 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан. Уг хуульд үндэсний бичигтэй холбоотой дараах заалтыг тусгажээ. Үүнд:

- 7 дугаар зүйлийн 2-т энэ хуулийн 11.1.2-т заасан “үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна”;
- 11 дүгээр зүйлийн 1.2-т “монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх”;
- 24 дүгээр зүйлийн 2-т 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Хуулийн хэрэгжилтийг хангахаар даган гарсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III-(2020-2024)”-ийг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор баталсан.

Дээрх хууль болон Засгийн газраас баталсан хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай статистикийн мэдээллийг бий болгох хэрэгцээ, шаардлагын улмаас төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулга, түүнийг нөхөх зааврыг боловсруулсан болно.

СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын мэдээллийн санд үндэслэн Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаанд хамрагдах нийт 159558 иргэнийг тодорхойлж, хүн бүрд тусгай эрх, нууц үгийг олгох замаар цахим орчинд мэдээлэл цуглууллаа. Төрийн болон албаны нууцын тухай хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн судалгаанд төрийн тусгай албан хаагчдыг хамруулаагүй болно.

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ

№	Ойлголт	Тодорхойлолт
ТӨРИЙН АЛБАН ХААГЧ		
1	Төрийн албан хаагч	Төрийн албан тушаалыг эрхэлж, эрх, үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг хэлнэ.
2	Төрийн байгууллага, албан газар	"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д зааснаар "Төрийн байгууллага, албан газар" гэдэг нь төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг хэлнэ.
3	Төрийн алба	Төрийн зорилт, чиг үүргийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх, төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалтыг хэлнэ.
БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ		
4	Бичиг үсэг мэддэг	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) өдөр тутмын амьдралын тухай хамгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаг, энэ чадвар нь тодорхой хугацаа өнгөрсөн ч хэвээр хадгалагдаж үлдсэн хүнийг Бичиг үсэг мэддэг гэж үзнэ.
5	Бичиг үсэг мэддэггүй	Аль нэг хэлээр (бичгийн төрөл, хэлбэрээс үл хамааран) хамгийн энгийн богино өгүүлбэрийг уншиж, ойлгож, бичиж чаддаггүй, түүнчлэн унших бичих чадвараа тодорхой хугацааны дараа алдсан хүнийг Бичиг үсэг мэддэггүй гэнэ.
БОЛОВСРОЛ		
4	Боловсролгүй	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгсөөгүй бол Боловсролгүй хүн гэнэ. Мөн 2020 онд ЕБС-ийн 1-5 дугаар ангид сурч байгаа, сурч байгаад сургуулиа орхисон хүмүүсийг Боловсролгүй гэж үзнэ.
5	Бага боловсрол	ЕБС-ийн 3 дугаар ангийг 1975-1996 онуудад, 4 дүгээр ангийг 1975 он хүртэл болон 1997-2004 онуудад, 5 дугаар ангийг 2005 оноос хойш төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн хүн.
6	Бүрэн бус дунд (суурь) боловсрол	ЕБС-ийн 7 дугаар ангийг 1975 он хүртэл, 8 дугаар ангийг 1975-2004 онуудад, 9 дүгээр ангийг 2005 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, суурь боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, суурь боловсролын гэрчилгээтэй хүн.
7	Бүрэн дунд боловсрол	ЕБС-ийн 10 дугаар ангийг 2005 он хүртэл, 11 дүгээр ангийг 2006-2014 онуудад, 12 дугаар ангийг 2015 оноос хойш өдөр, орой эчнээгээр төгссөн, мөн албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалтад хамрагдаж төгссөн, бүрэн дунд боловсролын аттестат ба үнэмлэхтэй хүн.
8	Техникийн болон мэргэжлийн боловсрол	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (хуучнаар техник, мэргэжлийн сургууль-ТМС) төгссөн, мэргэжлийн үнэмлэхтэй хүн.
9	Тусгай мэргэжлийн дунд боловсрол	Гадаад, дотоодын тусгай мэргэжлийн дунд сургууль (хуучнаар техникум), түүнтэй адилтгах сургууль төгссөн, үнэмлэх, дипломтой хүн.
10	Дээд боловсрол	Гадаад, дотоодын их, дээд сургууль, коллежийг өдөр, орой, эчнээгээр төгссөн, дипломын дээд, бакалавр, магистр, докторын зэргийн диплом болон түүнтэй адилтгах боловсролын баримт бичиг бүхий хүмүүсийг Дээд боловсролтой гэж үзнэ. Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 90 багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 120, магистрын сургалт 150, докторын сургалт 210 багц цагаас тус тус доошгүй байна. Түүнчлэн Улсын багшийн их сургуулийг 1964 оноос өмнө 3 жилээр, Намын дээд сургуулийг 1966 оноос өмнө, Намын дээд сургуулийн дэргэдэх 2 жилийн курс, Марксизм-Ленинизм оройн дээд сургууль Дорно дахины хөдөлмөрчдийн их сургууль (КУТВ) төгссөн хүмүүсийг дипломын дээд боловсролтой гэж үзнэ.

СУДАЛГААНД АШИГЛАСАН АНГИЛАЛ

Төрийн улс төрийн албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон болзол, журам, шалгуурын дагуу сонгогддог болон уг сонгуулийн үр дүнд томилолтын журмаар ажиллах, мөн тэдгээрийн бүрэн эрхийн хугацаанд өөрт нь үйлчлэх орон тооны дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Монгол Улсын Ерөнхийлөгч;
- Монгол Улсын Их Хурлын дарга;
- Монгол Улсын Ерөнхий сайд;
- Монгол Улсын Их Хурлын дэд дарга, гишүүн;
- Монгол Улсын Засгийн газрын гишүүн;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга;
- Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд сайд;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Монгол Улсын Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх;
- Бүх шатны Засаг дарга болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын орлогч;
- Улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтны албан тушаал;
- Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн ажлын албаны албан тушаал;
- Хуульд заасан бусад албан тушаал.

Мөн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, хот, тосгоны захирагчийн албан тушаалыг төрийн улс төрийн албан тушаалтай адилтган үзэж болно. Улс төрийн албан хаагчийн бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх орон тооны зөвлөх, туслах, хэвлэл мэдээллийн ажилтан нь тухайн албан тушаалтанд шууд захирагдах боловч төрийн албан хаагчийн хувьд тухайн байгууллагад харьяалагдана.

Төрийн захиргааны албан тушаалд Төрийн бодлого боловсруулахад мэргэшлийн зөвлөгөө өгөх, уг бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны удирдлагаар хангах, зохион байгуулах чиг үүрэг бүхий дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүн, ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэцийн ажлын алба, шүүхийн захиргаа, прокурорын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний Статистикийн хороо, Сонгуулийн ерөнхий хороо, Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Яамны Төрийн нарийн бичгийн дарга, яамны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын агентлагийн удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх улсын төсвөөс санхүүждэг нутгийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаал;

- Хот, тосгоны захирагчийн ажлын албаны удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Хуульд заасан бусад албан тушаал.

Төрийн тусгай албан тушаалд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд заасан журмын дагуу үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журам болон хууль дээдлэх үндсэн зарчмыг сахиулахтай холбогдсон төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүхийн шүүгч, прокурор;
- Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга;
- Монгол банкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд, Дэд ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүн, Үндэсний статистикийн хорооны дарга, дэд дарга, Сонгуулийн ерөнхий хорооны дарга, нарийн бичгийн дарга, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга, гишүүн, Үндэсний болон орон нутгийн аудитын газар, Авлигатай тэмцэх газрын удирдах, гүйцэтгэх албан тушаал;
- Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага;
- Дипломат албан тушаал;
- Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдал, тагнуул, цагдаа, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гаалийн байцаагч, шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч, мэргэжилтэн;
- Хуульд заасан бусад албан тушаал.

Төрийн үйлчилгээний албан тушаалд Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллах дараах албан тушаал хамаарна. Үүнд:

- Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаал;
- Боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт зэрэг төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын дарга, захирал, эрхлэгч, бусад удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал;
- Яам, агентлагийн харьяа болон түүний дэргэд ажилладаг, төсвөөс санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаал.

Төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалыг доор дурдсанаар ангилна. Үүнд:

Тэргүүн түшмэл: Яамны Төрийн нарийн бичгийн дарга, түүнтэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

Эрхэлсэн түшмэл: Яамны газрын дарга, хэлтсийн дарга, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

Ахлах түшмэл: Яамны тасгийн дарга, ахлах шинжээч, шинжээч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

Дэс түшмэл: Яамны ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн, ахлах зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.

Туслах түшмэл: Яамны зохион байгуулагч, тэдгээртэй адилтгах бусад албан тушаал хамаарна.


АСУУЛГЫН ХУУДАС

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгааны асуулга нь нийт 17 асуулттай бөгөөд төрийн албан хаагчийн ерөнхий мэдээллийн 11 асуулт, үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох 6 асуултаас бүрдсэн.


МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 4 дүгээр сарын 5-наас 30-ны өдрүүдэд орон даяар зохион байгуулсан.

ХҮЙС



НАСНЫ АНГИЛАЛ



ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН ТӨРӨЛ



ТӨРИЙН АЛБАН ТУШААЛЫН АНГИЛАЛ




Эх үүсвэр: Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн тайлан

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Үндэсний Статистикийн хорооноос анх удаа 2021 онд “Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа”-г Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн захиалгаар зохион байгууллаа.

Энэхүү судалгаанд төрийн 149.1 мянган албан хаагчийг хамруулж, оролцогчдоос нас, хүйс, эзэмшсэн мэргэжил, боловсрол, эрхэлж буй ажил, төрийн албаны ангилал зэрэг ерөнхий мэдээлэл цуглуулахаас гадна Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, сургалтад хамрагдах хэрэгцээ байгаа эсэх, сургалтыг ямар хэлбэрээр авч болох талаарх дараагийн шатны үйл ажиллагааг төлөвлөхөд шаардлагатай мэдээллийг цуглуулсан.

Зураг 1. Төрийн албан хаагчид, боловсролын түвшнээр, хувиар



Судалгаанд хамрагдсан нийт албан хаагчдын 28.6 хувь нь эрэгтэйчүүд, 71.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн 16.9 хувь нь 18-29 настай, 62.5 хувь нь 30-49 настай, 20.3 хувь нь 50-64 настай, 0.4 хувь нь 65-аас дээш настай байна.

Төрийн албан хаагчдыг эзэмшсэн боловсролын түвшнээр нь харвал 48.5 хувь нь бакалавр, 13.9 хувь нь магистр, 13.6 хувь нь бүрэн дунд боловсролтой, 6.5 хувь нь тусгай мэргэжлийн дунд боловсролтой, 6.3 хувь нь дипломын дээд боловсролтой, 4.2 хувь нь суурь боловсролтой, 1.1 хувь нь бага боловсролтой, 1.0 хувь нь доктор, 0.2 хувь нь


боловсролгүй байна.

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн судалгаанд хамрагдсан албан хаагчдыг төрийн албаны албан тушаалын төрлөөр ангилбал 63.0 хувь нь гүйцэтгэх, 28.7 хувь нь туслах, 8.3 хувь нь удирдах албан тушаалтан байна.


Төрийн албан хаагчдад эзлэх гүйцэтгэх албан тушаалтан Улаанбаатар хотод 66.0 хувь, Дархан-Уул аймагт 65.0 хувь, Говьсүмбэр аймагт 64.9 хувь, Завхан аймагт 64.9 хувь, Баянхонгор аймаг 64.3 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр хувьтай байна.

Төрийн албан хаагчдад эзлэх туслах албан тушаалтан Баян-Өлгий аймагт 35.2 хувь, Орхон аймагт 34.1 хувь, Дорнод аймагт 33.9 хувь, Сэлэнгэ аймагт 32.4 хувь, Төв аймагт 32.1 хувь байгаа нь улсын дунджаас дээгүүр байна.


Зураг 2. Төрийн албан хаагчид, албан тушаалын төрлөөр, аймаг, нийслэлээр, хувиар



9
 8
 7
 6
 5
 4
 3
 2
 1



6
 5
 4
 3
 2
 1



1. Бүтнээр унших чадвартай
 2. Зарим хэсгийг унших чадвартай
 3. Огт үншиж чадаагүй

- Бүтнээр унших чадвартай
- Зарим хэсгийг унших чадвартай
- Огт үншиж чадаагүй


ҮНДЭСНИЙ БИЧИГТ ШИЛЖИХЭД БЭЛЭН ЭСЭХ, СУРГАЛТЫН ХЭРЭГЦЭЭ

Монгол хэлний тухай хуулийн 7.2-т “үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна”, 24.2-т “Энэ хуулийн 7.2 дахь хэсгийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө” гэж тус тус заасныг үндэслэн судалгааны асуулгад “2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд Та бэлэн үү?” гэсэн асуултыг тавьсан.

Уг асуултад судалгаанд хамрагдагчид дараах байдлаар хариулжээ.

Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх асуултад судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 53.6 хувь нь “Тийм” гэсэн бол үлдсэн 46.4 хувь нь “Үгүй” гэж хариулсан (Зураг 3).

Зураг 3. Албан хэргээ кирилл болон Үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн байдал, аймаг, нийслэлээр, хувиар




Баян-Өлгий аймгийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 62.5 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн биш буюу “Үгүй” гэж хариулсан нь улсын дундаж болон бусад аймагтай харьцуулахад төрийн албан хаагчдын үндэсний бичгийн талаарх ойлголт, мэдлэг бага байгааг илтгэж байна.

Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчдын 74.7 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулсан нь нь улсын дундаж болон бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлт юм.

Говь-Алтай аймгийн удирдлагын шийдвэрээр тус аймаг нь 2021 оны 4 дүгээр сараас эхлэн орон нутгийн албан хэргийг Үндэсний бичигтэй хослуулан хэрэглэж байгаа бөгөөд аймгийн төрийн албан хаагчдыг Үндэсний бичгийн сургалтад хамруулж эхэлсэн байна. Тус аймгийн төрийн албан хаагчид эхний шатны сургалтад хамрагдсан хэдий ч судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 74.7 хувь нь албан бичиг хэргээ Үндэсний бичигтэй хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулснаас харахад сургалтын ач холбогдол нэлээд их байгааг илтгэж байна. Сургалтын хэрэгцээ, шаардлага чухал байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа бөгөөд сургалтад хамрагдахын ач холбогдлыг ч үнэлж болох юм.

Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ, шаардлага байгааг тодруулахад Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчдын 93.0 хувь нь хэрэгцээ, шаардлага байгаа гэж хариулснаас сургалтад хамрагдахын ач холбогдлыг үнэлж, бодит байдлыг мэдэрсэн байгааг судалгааны үр дүн харуулж байна (Зураг 4).

Зураг 4. Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх, аймаг, нийслэлээр, хувиар




Төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтын хэрэгцээ, шаардлага байгаа эсэх асуултад судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 85.0 хувь нь “Тийм” гэсэн бол үлдсэн 15.0 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байхгүй гэж үзсэн байна.

Энэ үзүүлэлтийг аймгаар харвал Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчдын 93.0 хувь, Баянхонгор аймгийн 91.4 хувь, Булган аймгийн 91.1 хувь, Завхан аймгийн 90.9 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байна гэсэн бол Баян-Өлгий аймгийн 25.6 хувь, Нийслэлийн төрийн албан хаагчдын 18.2 хувь, Дархан-Уул аймгийн 16.7 хувь, Дорнод аймгийн 15.6 хувь, Орхон аймгийн төрийн албан хаагчдын 15.5 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байхгүй гэсэн байна.

Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа төрийн албан хаагчдын хувьд ямар төрлийн сургалтад хамрагдах хүсэлтэй байна гэсэн асуултад 56.1 хувь нь танхимын сургалт, 43.1 хувь нь цахим сургалт, 0.8 хувь нь бусад хэлбэрийн сургалтад хамрагдах хүсэлтэй гэсэн байна. Мөн хосолмол хэлбэрээр сургалтад хамрагдах хүсэлтэй иргэд судалгаанд хамрагдагчдын 7.3 хувийг эзэлжээ.

Энэ үзүүлэлтийг аймаг, нийслэлээр харахад танхимаар заалгах хүсэлтэй байгаа албан хаагчид Говь-Алтай аймагт хамгийн өндөр (78.4) хувийг эзэлж, харин Улаанбаатар хотын төрийн албан хаагчид цахим хэлбэрээр сурахыг илүүд үзжээ (Зураг 5).


Зураг 5. Сургалт зохион байгуулах хэлбэр, аймаг, нийслэлээр, хувиар



Сургалтыг ямар хэлбэрээр зохион байгуулбал оновчтой байхыг хариулсан иргэдийг насны бүлгээр авч үзвэл наснаас үл хамааран танхимын сургалтад хамрагдахыг хүссэн хүмүүс 54.5-60.8 хувийг эзэлж байна. Үүний дотор залуучууд буюу 18-19 насныхан хамгийн өндөр хувьтай байна.

Судалгаанд бусад хэлбэрээр сурахыг хүсэж буй иргэдийн дийлэнх нь сургалтын хэлбэрээс гадна юу сурахыг хүсэж байгаагаа илүү тодорхойлж бичсэн байна. Тухайлбал, эхнээс нь заалгах, Ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн багшаар анхан шатнаас нь эхэлж заалгах, бичих чадвараа дээшлүүлэх, дүрэм заалгах, монгол бичгийн мэргэжлийн сургалт (уран бичлэг, каллиграф, таталган бичиг, эвхмэл бичиг, цахимд бичих чадвар)-нд хамрагдах, арван хуруугаар компьютер дээр шивж сурах, хуулийн нэр томъёо болон гадаад үгнүүдийг сурах дүрмийн сургалт, уламжлалт болон өвөрмөц бичлэгтэй үг нүдлэх, үндэсний бичгээр компьютер дээр стандартаар бичиж сурах зэргээр бичжээ.

Зураг 6. Сургалт зохион байгуулах хэлбэр, насны бүлгээр, хувиар



Харин “Бусад” хэлбэрийн сургалт гэдэгт хосолмол хэлбэрээр, ТВ хичээл байдлаар, цахим платформ дээр, өөрийн тохиромжтой цагт хэдэн ч удаа үзэж болох байдлаар, гарын авлагатай цахим хэлбэрийг хослуулах замаар, гарын авлага, толь бичиг ашиглах байдлаар, төрөл бүрийн аппликейшн ашиглан сурах, ажлын байран дахь сургалт, багаар суралцах, хамт олон, байгууллагаар нь сургалтад хамруулах, вакум орчинд сурах, бүх агуулгыг багтаасан сурах бичгээр хангах, үндэсний шилдэг багш нарын сурах бичгийг судлах, түвшин түвшнээр нь бүлэглэн цөөн хүнтэй анги болгож заах, компьютер болон утсан дээр бичих боломж бүрдүүлэх, мэргэжлийн багшаар заалгах, орон нутагт нь сургагч багшаар заалгах зэрэг санал өгсөн байна. Түүнчлэн санал, хүсэлт бичсэн байна. Үүнд:


- Одоогоос ЕБС-ийн хүүхдүүдэд эхнээс нь заагаад тэр үеэсээ эхлэн монгол бичигт шилжсэн нь дээр гэж бодож байна.
- Телевизээр гаргадаг хэрэггүй олон киноны оронд монгол бичгийн хичээлийг байнга зааж, хүмүүсийн харааны баримжаанд байнга нэвтрүүлэх.
- Үндэсний бичгээрээ бичих, унших чадвартай байх ёстой. Бага ангид ордог байсныг болиулсан нь алдаа болсон. Тиймээс монгол бичигтэй бага ангийн багш нар эрс цөөрсөн.
- Хэл бол хэрэгцээ танхимаар суралцах.
- Цар тахалгүй бол танхимаар суралцах нь дээр байнга интернэт ашигладаггүй болохоор онлайн хэцүү байдаг.
- Мэргэжлийн багш нарын мэдлэгийг гүнзгийрүүлэх, дээшлүүлэх.
- Үр дүнтэй танхимын сургалт хийх. Сая болсон сургалт чанар муутай байсан.
- 1991 онд анхны Монгол бичигтэн 1 дүгээр ангид орж байсан. Чөлөөтэй уншдаг. Бичихэд бага зэрэг алддаг болсон байна лээ.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зааж буй хичээлийг бичлэг хэлбэрээр авч танхимын залхуу хүрмээр нэг хэвийн сургалтаас илүү үр дүнтэй суралцах.

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ

Судалгааны зорилготой уялдуулан сургалтын хэрэгцээг судлахын зэрэгцээ төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг тодорхойлсон.

Судалгааны дүнгээр судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 5.2 хувь нь өөрийнхөө үндэсний бичгийн түвшинг “Маш сайн” гэж үнэлсэн бол 13.4 хувь нь сайн, 28.7 хувь нь дунд зэрэг, 25.4 хувь нь бага зэрэг, 27.2 хувь нь үндэсний бичгийн үсэг, тоо мэдэхгүй, ялгахгүй, уншихгүй, бичихгүй буюу ямар нэгэн мэдлэг огт байхгүй гэж хариулжээ. Энэ үзүүлэлтийг аймаг, нийслэлээр Зураг 7-д харуулав.


Зураг 7. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, аймаг, нийслэлээр, хувиар



Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021 Баян-Өлгий, Говьсүмбэр, Ховд аймгийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 30.6-62.3 хувь нь үндэсний бичгийн мэдлэггүй гэсэн нь бусад аймагтай харьцуулахад үндэсний бичгийн мэдлэггүй алба хаагчийн хувь хамгийн өндөр байна. Харин Сүхбаатар, Увс, Хэнтий, Булган аймгийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 5.5-6.4 хувь нь үндэсний бичгийн мэдлэг маш сайн гэсэн нь бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр байна.


Баян-Өлгий аймгийн хувьд төрийн албан хаагчдын 62.3 хувь нь үндэсний бичгийн мэдлэггүй, 2.2 хувь нь үндэсний бичгийн маш сайн мэдлэгтэй байгаа нь бусад аймагтай харьцуулахад хамгийн доогуур үзүүлэлт болж байгаа нь цаашид төрийн албан хэрэг хөтлөлтийг үндэсний бичгээр явуулахад ихээхэн анхаарал хандуулах хэрэгтэй байгаа нь харагдаж байгаа юм. Түүнчлэн төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийн түвшинг насны бүлгээр авч үзвэл 35-39 насны төрийн албан хаагчдын 7.1 хувь нь үндэсний бичгийн мэдлэг маш сайн, 19.1 хувь нь сайн, 32.5 хувь нь дунд зэрэг, 22.9 хувь нь бага зэрэг, 18.5 хувь нь мэдлэггүй гэж хариулсан бөгөөд энэ нь бусад насны бүлэгтэй харьцуулахад үндэсний бичгийн мэдлэг сайн байгаа нь тухайн насны бүлгийн иргэд Ерөнхий боловсролын сургуульд үндэсний бичгийг илүү олон жилээр заалгаж байсантай холбоотой нь харагдаж байна.

Зураг 8. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, насны бүлгээр, хувиар



Мөн төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг үндэсний бичиг сурч байсан хугацаагаар тооцоход сурсан хугацаанаас мэдлэгийн түвшин шууд хамаарч байгааг доорх зургаас харж болно.

Зураг 9. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, үндэсний бичиг заалгасан жилээр, хувиар




Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдаас үндэсний бичгийг ямар хугацаанд үзсэн бэ гэсэн асуултад хамгийн дээд тал нь 6 жил гэж хариулсан байна.

Үндэсний бичгийг үзсэн жил болон мэдлэгийн түвшинтэй уялдуулж харвал 6 жил үндэсний бичиг үзсэн төрийн албан хаагчдын 49.6 хувь нь маш сайн мэддэг, 34.2 хувь нь сайн мэднэ, 12.7 хувь нь дунд зэрэг мэднэ, 3.5 хувь нь бага зэрэг гэж хариулсан байна. Харин 1 хүртэл жил үндэсний бичиг үзсэн төрийн албан хаагчдын 59.2 хувь нь бага зэрэг мэддэг, 33.5 хувь нь дунд зэрэг мэддэг, 6.2 хувь нь сайн мэднэ, 1.2 хувь нь маш сайн мэддэг гэж хариулжээ.


Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг төрийн албаны албан тушаалын төрлөөр харвал удирдах албан тушаалтай алба хаагчдын 6.5 хувь нь маш сайн мэдлэгтэй, 18.2 хувь нь сайн мэдлэгтэй, 32.6 хувь нь дунд зэрэг мэдлэгтэй, 24.7 хувь нь бага зэрэг мэдлэгтэй, 18.1 хувь нь мэдлэггүй гэсэн бол гүйцэтгэх албан тушаалтай алба хаагчдын 6.4 хувь нь, туслах албан тушаалтай алба хаагчдын 2.0 хувь нь маш сайн мэдлэгтэй гэж хариулжээ.

Зураг 10. Үндэсний бичгийн мэдлэгийн түвшин, төрийн албан хаагчийн албан тушаалын төрлөөр, хувиар



Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг өөрсдийнх нь үнэлгээгээр авахаас гадна, судалгаагаар тодорхой эхийг уншуулж, давхар үнэлгээ хийсэн. Уг эхийг уншсан байдлыг дараах Зураг 11-т харууллаа. Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 50.9 хувь нь өгөгдсөн эхийн зарим хэсгийг унших чадвартай, 38.8 хувь нь бүтнээр нь унших чадвартай бол 10.3 хувь нь тухайн эхийг огт уншиж чадаагүй байна.

Зураг 11. Өгөгдсөн эхийг унших чадвар, хувиар




Ус бол амьдралын амин чухал эх булаг мөн. Хүн амьтны усны хэрэгцээ нэн их. Насанд хүрсэн хүний биеийн жингийн 65-70 хувийг ус эзлэх боловч эрхтэн бүрд адилгүй хэрэгцээтэй байдаг. Шүдний паланд ус хамгийн багаар хэрэглэгдэнэ.

Ус бол амьдралын амин чухал эх булаг мөн. Хүн амьтны усны хэрэгцээ нэн их. Насанд хүрсэн хүний биеийн жингийн 65-70 хувийг ус эзлэх боловч эрхтэн бүрд адилгүй хэрэгцээтэй байдаг. Шүдний паланд ус хамгийн багаар хэрэглэгдэнэ.

Өгөгдсөн эхийг уншсан байдлыг үндэсний бичиг үзсэн жилтэй холбож харвал 6 жил үндэсний бичиг үзсэн алба хаагчдын 89.3 хувь, 5 жил үзсэн алба хаагчдын 72.7 хувь, 4 жил үзсэн алба хаагчдын 60.9 хувь, 3 жил үзсэн алба хаагчдын 48.4 хувь, 2 жил үзсэн алба хаагчдын 32.2 хувь, 1 хүртэл жил үзсэн алба хаагчдын 16.8 хувь нь өгөгдсөн эхийг бүтнээр нь унших чадвартай байна. Харин 1 хүртэл жил үзсэн алба хаагчдын 20.9 хувь нь өгөгдсөн эхийг огт уншиж чадаагүй байна.

Зураг 12. Өгөгдсөн эхийг унших чадвар, үндэсний бичиг үзсэн жилээр, хувиар





ДҮГНЭЛТ

- Албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн эсэх асуултад судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 53.6 хувь нь “Тийм” гэсэн бол үлдсэн 46.4 хувь нь “Үгүй” гэж хариулсан.
Улсын дундаж болон бусад аймагтай харьцуулахад Говь-Алтай аймгийн төрийн албан хаагчдын 74.7 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн гэж хариулсан нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Баян-Өлгий аймгийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 62.5 хувь нь албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд бэлэн биш буюу “Үгүй” гэж хариулсан байна.
- Төрийн албан хэрэг хөтлөлтийг цаашид үндэсний бичгээр явуулахад төрийн албан хаагчдын мэдлэг, чадварт онцгой анхаарал хандуулах нь зүйтэй.
Баян-Өлгий, Говьсүмбэр, Ховд аймгийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 30.6-62.3 хувь нь үндэсний бичгийн мэдлэггүй гэсэн нь бусад аймагтай харьцуулахад үндэсний бичгийн мэдлэггүй алба хаагчийн хувь хамгийн өндөр байна. Харин Сүхбаатар, Увс, Хэнтий, Булган аймгийн судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 5.5-6.4 хувь нь үндэсний бичгийн мэдлэг маш сайн гэсэн нь бусад аймагтай харьцуулахад хамгийн өндөр байна.
- Үндэсний бичгийн мэдлэгийг төрийн албаны албан тушаалын төрлөөр харвал удирдах албан тушаалтай алба хаагчдын 6.5 хувь нь маш сайн мэдлэгтэй, 18.2 хувь нь сайн мэдлэгтэй, 32.6 хувь нь дунд зэрэг мэдлэгтэй, 24.7 хувь нь бага зэрэг мэдлэгтэй, 18.1 хувь нь мэдлэггүй гэсэн бол гүйцэтгэх албан тушаалтай алба хаагчдын 6.4 хувь нь, туслах албан тушаалтай алба хаагчдын 2.0 хувь нь маш сайн мэдлэгтэй гэж хариулжээ.
- Өгөгдсөн эхийн зарим хэсгийг судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 50.9 хувь нь унших чадвартай, 38.8 хувь нь бүтнээр нь унших чадвартай бол 10.3 хувь нь тухайн эхийг огт уншиж чадаагүй байна.
Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчдын 5.2 хувь нь өөрийнхөө үндэсний

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021 бичгийн түвшинг “Маш сайн” гэж үнэлсэн бол 13.4 хувь нь сайн, 28.7 хувь нь дунд зэрэг, 25.4 хувь нь бага зэрэг, 27.2 хувь нь үндэсний бичгийн үсэг, тоо мэдэхгүй, ялгахгүй, уншихгүй, бичихгүй буюу ямар нэгэн мэдлэг огт байхгүй гэж хариулжээ.

- Төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтын хэрэгцээ, шаардлага байгаа эсэх асуултад 85.0 хувь нь “Тийм” гэсэн бол үлдсэн 15.0 хувь нь сургалтын хэрэгцээ, шаардлага байхгүй гэжээ.
- Үндэсний бичгийн сургалтад хамрагдах хүсэлтэй байгаа төрийн албан хаагчдын 56.1 хувь нь танхимын сургалт, 43.1 хувь нь цахим сургалт, 0.8 хувь нь бусад хэлбэрийн сургалтад хамрагдах хүсэлтэй байна.
- Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг үндэсний бичиг сурч байсан хугацаагаар тооцоход сурсан хугацаанаас мэдлэгийн түвшин шууд хамаарч байна. Тухайлбал, 35-39 насны төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг бусад насны бүлэгтэй харьцуулахад сайн байгаа нь ерөнхий боловсролын сургуульд үндэсний бичгийг илүү олон жилээр заалгаж байсантай холбоотой.
- Төрийн албан хаагчдын “Үндэсний бичгийн мэдлэг тогтоох судалгаа”-г тодорхой жилийн давтамжтай хийж, хуулийн болон сургалт, зохион байгуулсан үйл ажиллагааныхаа хэрэгжилтийг бодитой дүгнэж байх, судалгааны мэдээлэлд үндэслэн дараагийн шатны үйл ажиллагаагаа төлөвлөх нь тодорхой үр дүнг авчирна.
- Эхний ээлжид үндэсний бичгийг албан ажилдаа зайлшгүй хэрэглэх шаардлагатай албан хаагчдыг шалгалтад хамруулж, мэдлэгийн түвшинг бодитой тогтоож, мэдлэгийн түвшинд нь тохируулан шат дараалсан сургалт зохион байгуулах нь үр дүнтэй юм.

АСУУЛГЫН ХУУДАС

Үндэсний статистикийн хорооны даргын 20... оны ... дугаар сарын ...-ний өдрийн .../... дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлав.

Маягт - МБ



ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА-2021

ХАЯГИЙН ХЭСЭГ		МВМ
МВМ1. Байгууллагын нэр		
МВМ2. Аймаг, нийслэлийн нэр, код	<input type="text"/>	МВМ6. Судалгаанд хамрагдсан огноо
МВМ3. Сүм, дүүргийн нэр, код	<input type="text"/>	2 0 2 1 / <input type="text"/> / <input type="text"/>
МВМ4. Төрийн албан хаагчийн овог, нэр		
МВМ5. Төрийн албан хаагчийн регистрийн дугаар	<input type="text"/>	<input type="text"/>

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ		МВВ
Танаас авсан бүх мэдээллийн нууцыг Монгол Улсын "Хувь хүний нууцын тухай" хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон "Статистикийн тухай" хуулийн 22 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу чандлан хадгалах бөгөөд ямар нэгэн нэргүйгээр зөвхөн судалгааны үр дүнг тооцоход ашиглана. Энэхүү судалгааны үр дүнд үндэслэн зөвхөн төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлж, цаашид үндэсний бичгийг төрийн албан ёсны үйл ажиллагаанд нэвтрүүлэхэд хэрэгцээтэй үе шаттай сургалтын төлөвлөгөө боловсруулах юм. Иймд судалгаанд үнэн зөв хариулахыг ТАНААС хичээнгүйлэн хүсэж байна.		

№	Асуулт	Хариулт	Алхам
МВВ1	Таны хүйс	Эрэгтэй	1
		Эмэгтэй	2
МВВ2	Та хэдэн настай вэ?	Бүтэн насыг бичнэ <input type="text"/>	
МВВ3	Та эзэмшсэн боловсролынхоо дээд түвшнийг хэлнэ үү? <i>Одоо сурч байгаа бол төссөн түвшнийг сонгоно. Жишээ нь: Одоо их, дээд сургуульд магистрын зэрэг хамгаалахаар сурч байгаа төсөөгүй, харин бакалаврын зэрэг хамгаалж, төссөн бол "8"-ыг сонгоно.</i>	Боловсролгүй	1
		Бага	2
		Суурь (8/9-р анги төгссөн)	3
		Бүрэн дунд (10/12-р анги төгссөн)	4
		Техникийн болон мэргэжлийн /МСҮТ/	5
		Тусгай мэргэжлийн дунд	6
		Дипломын дээд	7
		Бакалавр	8
		Магистр	9
		Доктор	10
МВВ4	Таны ажил эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиглэл юу вэ?	<input type="text"/>	
МВВ5	Та ямар ажил эрхэлдэг вэ?	<input type="text"/>	
МВВ6	Таны эрхэлдэг ажил төрийн албаны аль ангилалд хамаардаг вэ?	Төрийн улс төрийн алба	1 → МВВ8
		Төрийн захиргааны алба	2
		Төрийн тусгай алба	3 → МВВ8
		Төрийн үйлчилгээний алба	4 → МВВ8
МВВ7	Та төрийн захиргааны албан тушаалын аль ангилалд хамаардаг вэ?	Тэргүүн түшмэл	1
		Эрхэлсэн түшмэл	2
		Ахлах түшмэл	3
		Дэс түшмэл	4
		Туслах түшмэл	5
МВВ8	Таны эрхэлдэг ажил төрийн албан тушаалын аль төрөлд хамаардаг вэ?	Удирдах	1
		Гүйцэтгэх	2
		Туслах	3
МВВ9	2025 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагад албан хэргээ кирилл болон үндэсний бичгээр хослуулан хэрэглэхэд Та бэлэн үү?	Тийм	1
		Үгүй	2

Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-2021

Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэгийг тодорхойлох судалгаа - 2021			Хуудас 2
№	Асуулт	Хариулт	Алхам
MBV10	Танд цаашид үндэсний бичгийн сургалтад хамрагдах хэрэгцээ шаардлага байна уу?	Тийм 1 Үгүй 2	→ MBK1
MBV11	Та ямар хэлбэрийн сургалтад хамрагдахыг хүсэж байна вэ? Олон хариултын сонголттой.	Онлайн сургалт A Танхимын сургалт B Бусад X	
ҮНДЭСНИЙ БИЧГИЙН МЭДЛЭГ			MBK
MBK1	Та үндэсний бичиг /монгол бичиг/ мэддэг үү? <i>Мэдлэг маш сайтай</i> гэдэгт үндэсний бичгээр чөлөөтэй уншдаг, бичдэг, тоо мэддэг хүнийг ойлгоно. <i>Мэдлэг сайн</i> гэдэгт үндэсний бичгээр уншдаг боловч бичих эсвэл тоо мэдэх чадвар багатай хүнийг ойлгоно. <i>Мэдлэг дунд зэрэг</i> гэдэгт үсгээ бүгдийг мэддэг, зарим үгийг уншиж чадах хэдий ч хүндэтгэр үгийг уншиж чадахгүй хүнийг ойлгоно. <i>Мэдлэг бага зэрэг</i> гэдэгт үндэсний бичгийн зөвхөн үсгээ мэддэг, унших болон бичих, тоо мэдэх чадвар байхгүй хүнийг ойлгоно. <i>Мэдлэггүй</i> гэдэгт үндэсний бичгийн үсгээ, тоо мэдэхгүй ялгахгүй, уншихгүй, бичихгүй буюу ямар нэгэн мэдлэг оогт байхгүй хүнийг ойлгоно.	Тийм Маш сайн 1 Сайн 2 Дунд зэрэг 3 Бага зэрэг 4 Үгүй, мэдлэггүй 5	→ Дуусгах
MBK2	Та үндэсний бичгийг дунджаар хэр хугацаанд үзсэн бэ? 9 сар үзсэн бол сар гэдгийн нүдэнд "09" гэж бичнэ. Нэг бүтэн хичээлийн жилийг нэг жил гэж үзнэ.	Сар <input type="text"/> Жил <input type="text"/>	
MBK3	Та дараах эхийг уншина уу?	Огт уншиж чадаагүй 1 Зарим хэсгийг унших чадвартай 2 Бүтнээр нь унших чадвартай 3	→ MBK6 → MBK5
MBK4	Та егөгдсөн эхээс уншиж, утгыг ойлгосон үгийн тоог тоолж бичнэ үү? Хэрэв, 8 үг уншсан бол нүдэнд "08" гэж бичнэ.	Уншсан үгийн тоо <input type="text"/>	
MBK5	Танаас уншсан эхтэй холбоотой асуулт асууя. А) Ус хэдэн хувийг азална гэсэн бэ? Б) Хүний биеийн аль эрхтэнд ус бага хэрэглэгддэг вэ?	55-60 1 45-50 2 65-70 3 Хэл 1 Шүдний паалан 2 Элэг 3	
MBK6	Та үндэсний бичгээр бичиж чаддаг уу?	Тийм Сайн бичиж чадна 1 Дунд зэрэг бичиж чадна 2 Бага зэрэг бичиж чадна 3 Үгүй, бичиж чадахгүй 4	
Судалгаанд хамрагдсан танд баярлалаа			
Судалгаанд хамрагдсан төрийн албан хаагчийн тэмдэглэл			